



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2014 оны 04 сарын 09 өдөр

Дугаар 113

Улаанбаатар хот

“Дархан Импекс” ХК-ийн үнэт цаасыг
бүртгэлээс хасах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 63.1.10, Компанийн тухай хуулийн 23 дугаар зүйл, Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 06 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 22 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Дархан Импекс” ХК-ийн нийтэд санал болгон гаргасан нийт 668572 /зургаан зуун жаран найман мянга таван зуун далан хоёр/ ширхэг хувьцааг үнэт цаасны бүртгэлээс хасахыг Үнэт цаасны газар /Б.Саруул/, Хөрөнгийн биржийн жагсаалтаас хасахыг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Д.Болормаа/, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн бүртгэлээс хасахыг “ҮЦТТТХТ” ХХК /Т.Гандулам/-д тус тус үүрэг болгосугай.

2. Компанийн тухай хуулийн 24.1, 53.1 дэх заалтын дагуу өөрийн эзэмшиж байгаа хувьцааг компанид эргүүлэн авахыг шаардах эрх үүссэн хувьцаа эзэмшигчдэд шаардах эрх үүссэн тухай болон уг эрхийг хэрэгжүүлэх журмын талаарх мэдэгдлийг энэхүү тогтоол батлагдсан өдрөөс хойш ажлын 3 хоногт багтаан өдөр тутмын хэвлэл, мэдээллийн хэрэгслээр дамжуулан мэдээлэх, уг мэдээлэлд эрх үүссэн хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг тусгахыг “Дархан Импекс” ХК /Д.Амарбаяр/-д үүрэг болгосугай.

3. Шаардах эрхээ хэрэгжүүлээгүй хувьцаа эзэмшигч түүний дансанд байршуулсан ногдол хувийн мөнгөн хөрөнгийг авалгүйгээр хаалттай компанийн хувьцаа эзэмшигчээр үлдэх хүсэлтийг хэдийд ч гаргаж болохыг тэмдэглэсүгэй.

4. Тус компани хэлбэрээ өөрчилж, үнэт цаасны бүртгэлээс хасагдаж байгаатай холбогдуулан “Дархан Импекс” ХК /Д.Амарбаяр/, “ҮЦТТТХТ” ХХК /Т.Гандулам/-д дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг үүрэг болгосугай:

1/ Хувьцаагаа компанид эргүүлэн худалдан авахыг шаардах эрх үүссэн хувьцаа эзэмшигчдийн эзэмшилд байгаа хувьцаанд ногдох мөнгөн хөрөнгийг нэгж хувьцаанд 401,67 /дөрвөн зуун нэг төгрөг жаран долоон мөнгө/ төгрөгөөр тооцон “ҮЦТТТХТ” ХХК-д гэрээ байгуулан төвлөрүүлж, хувьцаа эзэмшигчдийн шаардах эрхийг хангах;

2/ Хувьцаа эзэмшигч өөрийн эзэмшиж буй хувьцааг компанид эргүүлэн худалдан авах шаардлагыг гаргасан тохиолдолд зохих журмын дагуу нэгж хувьцаанд ногдох мөнгөн хөрөнгийг хувьцаа эзэмшигчдэд шуурхай олгох;

000115

3/ Ногдол хувийн мөнгөн хөрөнгийг төвлөрсөн хадгаламж дахь дансанд байршуулахдаа хувьцаагаа компанид эргүүлэн худалдан авахыг шаардах эрх тухайн дансны эзэмшигчид үүссэн тухай тэмдэглэл хийж, харилцагч дансны хуулга авах тухай бүрд зохих тайлбарыг өгч ажиллах;

4/ Энэхүү тогтоолын 3-т заасан хүсэлтийг гаргасан тохиолдолд компанийн эзэмшил дэх хувьцаанаас хүсэлт гаргасан хувьцаа эзэмшигчид эзэмшүүлж, түүний хариуд уг хувьцаа эзэмшигчийн төвлөрсөн хадгаламжийн байгууллага дахь дансанд нь байршуулсан ногдол хувийн мөнгөн хөрөнгийг тус компанид шилжүүлж ажиллах.

5. Энэхүү тогтоол батлагдсанаас хойш ажлын 10 хоногийн дотор Улсын бүртгэлийн ерөнхий газарт мэдээлэл хүргэх, тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН